

“Хүүд итгээгүй мөхөх” хүн тамд орох уу?

Өмнөх хэдэн нийтлэлээс «Хуучин гэрээ»-нд там огт байхгүйг бид мэдсэн. Дээр нь, «Шинэ гэрээ»-нд “там” гэж орчуулсан Тартарус, Гехенна гэдэг хоёр газар байдаг боловч эдгээрийн шинж тэмдэг монгол хүний “там” гэсэн ойлголттой нийцэхгүйг мэдлээ. Тухайлбал: Тартарус хүнд биш, тэрсэлсэн тэнгэрэлчид зориулсан гяндан. Харин Гехенна бол Иерусалимын гаднах талд буй хөндий бөгөөд айсуу Хаант улсад цаазлагдсан гэмт хэрэгтний шарилыг шатаах газар болно.



Улмаар, Есүс “там”-ын (буюу Гехеннагийн) тухай ярьснаас өөр хаана ч «Шинэ Гэрээ»-д тамын тухай бичээгүй. Иохан энэ үгийг «Илчлэл» номдоо хүртэл нэг ч хэрэглээгүй. Пэтр бас энэ талаар дурсдаггүй. Тамын тухай «Үйлс» номд өгүүлээгүй, «Еврейчүүдэд» бичсэн захидал ч тайлбарлаагүй. Мөн еврей бусчууд бидэнд Ертөнцийн Эзэний “**бүхэл** төлөвлөгөөг мэдүүлсэн” Паул (Үйлс 20:27) нэг ч удаа “там”-г дурдсангүй.

Гэтэл энэ сэдвийн үнэн дэндүү чухал учраас бид хайнга хандаж болохгүй. “Там байдаггүй” гэж шууд дүгнэхийн оронд “үхэгсэд амьдаараа тамлагдаж буй мөнхийн зовлонт там” байдгийг харуулсан өөр үг Библид байгаа эсэхийг шалгая.



“Хүүд итгээгүй мөхөх” хүн тамд орох уу? □ 2

“Мөхөх тавилантай хүмүүс” яах вэ?

“Алдартай Иохан 3:16-ны дагуу **“Хүүд итгээгч хэн ч мөхөхгүй”**. Энэ мөхөх явдал мөнхийн тамд орохыг хэлдэг биз дээ” гэсэн ойлголт түгээмэл. “Бор” Библи энэ ишлэлийг тэр л утгаар буюу “Түүнд итгэсэн хүн мөнхийн



зовлонд орохгүй” гэж орчуулдаг.

Энэ зөв орчуулга мөн үү? “Мөхөх” гэсэн үг тийм утгатай юу?

“Мөхөх” гэж дээр орчуулсан грек үг ([ἀπόλλυμι](#), [аполлүми](#), G622) их сонирхолтой, «Шинэ Гэрээ»-нд 92 удаа гардаг учраас бүхэл бүтэн судалгаа болж чадна (дээрх линкнээс олоорой). Энд товчхон л судалъя. Энэ үгийн утга хэрэглээнээс нь харахад “алдах”, “мөхөх”, “сүйрэх”, “устах”, “үгүй болох”, “хөнөөлгөх” зэрэг ба ийм байдалд оруулахыг хэлнэ (=алдагдах, сүйрүүлэх, устгах, зайлуулах, хөнөөх г.м. бусдаар үйлдүүлэх хэвийн хэлбэр болно).

Шагнал, цэцгийн гоо сайхан зэрэг хийсвэр зүйл “алдагдан” буюу “устах” боломжтой (Матай 10:42; Иакоб 1:11).





“Хүүд итгээгүй мөхөх” хүн тамд орох уу? □ 3

Дээр нь энэ үгийг Израйлийн ард түмэн, дарс ба дарсны тулман, хонь, зоос, тэнэмэл хүү, алт зэрэг амьтай, амьгүй олон зүйлд хэрэглэсэн байна (Матай 15:24; Марк 2:22; Лук 15:4,8,24; 1 Петр 1:7). Эдгээр эд хогшил бүү хэл, хонь амьтан хүртэл тамд орох талаар ойлголт хэнд ч байхгүй биз ээ. Израйлийн ард түмэн, тэнэмэл хүү хоёр мөн тамд орсныг хэлээгүй нь хэн бүхэнд ойлгомжтой.

Есүст хүртэл тус үг хэрэглэгдсэн байна. Эхлээд Херод хаан түүнийг “хөнөөх” санаатай байв (Матай 2:13). Дараа нь, ахлах тахилч нар захирагч Пилатад хандан түүнийг цаазаар “хөнөөлгөхийг ятгасан” (Матай 27:20). Есүсийг мөнхийн зовлонт тамд хаяхыг тэд Пилатаас хүссэн гэж үү? Мэдээж үгүй. Түүнийг зайлуулж үгүй болгохыг хүссэн нь ойлгомжтой.

Мөхөх, алдагдах шалтгаан “Хүүд итгээгүй”-гээс өөр янз бүр байдаг. Хүүд итгээгүй биш итгэсэн дагалдагч нар живж “сөнөх”-өөс айгаад байсан (Матай 8:25).





“Хүүд итгээгүй мөхөх” хүн тамд орох уу? □ 4

Мөхөх гэдэг нь үхэхийг хэлдэг нь дахин харагдаж байна. Гэтэл хонь, тэнэмэл хүү хоёр тэнэснээс болоод “алдагдсан” (Лук 15:4). Тэд үхээгүй, харин хоньчин ба эцгийнхээ хувьд үгүй болсон байв. Энэ бол шилжсэн утгатай юм.

Улмаар, бид итгэлийн ахан дүүсээ хоол юмуу мэдлэгээрээ “устгаж” болдог нь гайхмаар. Үүнд: **“Хэрэв идэх юмнаас болж ах дүүгээ гомдоовол, та нэгэнт хайрын дагуу явахгүй байна. Та тэр хүнийг идэх юмаараа бүү устга. (...) Идэх юмнаас болж Бурханы ажлыг бүү нураа. (...) Мах идэхгүй, дарс уухгүй, эсвэл ах дүү чинь бүдэрдэг ямар нэгэн зүйлийг үйлдэхгүй байх нь сайн.”** (Ром 14:15,20-21; 1 Коринт 8:11)

Итгэлийн ах дүүгээ хэрхэн “устгах”-ыг Паулын дараах үгнээс ойлгож болно. “Ах дүүгээ устгах” гэсэн нь түүнийг “гомдоох”, “бүдрүүлэх” замаар амьдралд нь хийгдэж буй Их Эзэний ажлыг “нураах” явдал юм. Үүнээс ч харахад хүнийг “устгах” гэдэг нь “мөнхийн зовлонт тамд оруулах” гэсэн үг биш. Христ үнэт цусаараа итгэлийн ах дүүст маань авч





“Хүүд итгээгүй мөхөх” хүн тамд орох уу? □ 5

өгсөн авралыг бид идэх уухаараа хэрхэн үгүй болгох вэ дээ, тийм зүйл огт боломжгүй хэрэг.

“Мөхсөн” буюу “алдагдсан” байдлаас болж хохирох хоёр тал байдгийг анзаарах нь чухал. Тэнэмэл хүү аавынхаа хувьд алдагдсан, хонийг хоньчин нь алдсан, олон израйльчууд Ертөнцийн Эзэний хувьд алдагдсан, итгэгч “устгагдах” тохиолдолд Их Эзэний амьдралд нь хийсэн ажил үгүй болно. Тэнэмэл хүү, хонь бас буруу замаар явсан израйльчууд, итгэгч хүмүүс зовсон нь мэдээж.

Гэтэл хонио алдсан хоньчины хохирол, эсвэл ард түмнээ алдсан Ертөнцийн Эзэний амссан хохирлыг зовлонд тооцох хэрэггүй гэж үү?

Тэнэмэл хүүгийн аавын сэтгэл ямар хэцүү байсныг хүүхэдтэй хүн бүр ойлгоно.

Тэгэхээр

“алдагдаж мөхсөн”

хүн төрөлхтөн

гарах гарцгүй

мөнхийн зовлонт

тамд орвол Хэн

хамгийн их хохирч

зовох вэ?





“Хүүд итгээгүй мөхөх” хүн тамд орох уу? □ 6

Энэ бүхнээс дүгнэхэд хүн “мөхөх” гэдэг нь тамтай ямар ч холбоогүй, харин яг л монгол утгаараа “үхээд үгүй болох”-ыг хэлнэ.

Эсвэл шилжсэн утгатай байхаар хүн ямар нэгэн байдлаар замаа алдаж “алдагдах”-ыг хэлнэ.

Замаа алдаж, Хүүд итгээгүй хүн төрөлхтөн үхээд үгүй болно гэсэн үг.¹

Ингэхэд тэдэнд ямар ч найдвар байхгүй гэж үү?



Найдвар байна!

Тэнэмэл хүү өөрийн байдлаа ухаарсны дараа аав нь хүүгээ “үхсэн боловч амь оржээ, алдагдсан боловч олдлоо” гэв (Лук 15:17,24). Үүнчлэн алдагдаж үхсэн хүн төрөлхтөн дахин амилахдаа юмны учрыг

- 1 Энэ утгаар мөн 2 Тесалоник 1:9-г ойлгох хэрэгтэй. Энэ хэсэг Есүс Их Эзэнийг эргэж ирэхэд сайн мэдээг нь дагахыг хүсээгүй амьд яваа хүмүүсийн тухай. Тэд “мөнх [грек: эоний] сүйрлийн шийтгэлийг авч, Эзэний оршихуй [грек: царай] ба Түүний хүчний алдраас сална” гэж Паул анхааруулсан. “Сүйрэл” гэж орчуулсан үг “мөхөх” гэсэнтэй адилхан үндэс бүхий үг. Тэд «Илчлэл» номын үзэгдэлд үхдэг олон хүний тоонд орно гэсэн үг. Энэ шийтгэл нь айсуу эон үеийн турш (цагаан сэнтийн шүүх хүртэл!) үргэлжилнэ. Үхэх замаар тэд Их Эзэний ивээл дүүрэн оршихуйгаас салах болно. Үйлс 3:19-н дагуу “Их Эзэний оршиуугаас сэргээх цаг” ирнэ. Энэ нь мянган жилийн Хаант улсыг хэлсэн хэллэг. “Их Эзэн царайгаа чиний дээр гэрэлтүүлэх болтугай” гэсэн ерөөлийн үг Түүний таалалд багтаж ивээгдэхийг хэлнэ (Тооллого 6:25). Тэгэхээр тэдний шийтгэл мянган жилийн Хаант улсын бүх ивээл, жаргалаас хасагдахад оршино (1Тесалоник 5:3-г мөн энэ утгаар ойлгоно).



“Хүүд итгээгүй мөхөх” хүн тамд орох уу? □ 7

олж, Бүтээгч Эзэндээ эргэж очих ёстойг
Бичвэрүүдийн олон ишлэлээс ойлгогдоно.

Мөхөх хүн төрөлхтөний хувь
заяаг тодорхойлох гол ишлэл
бол энэ:

Есүс **“алдагдсаныг хайж,
аврахаар ирсэн”** (Лук 19:10).

Энэ үгээ Есүс албан татвар
хураагчдын ахлагч

Закхайгийнд байхдаа хэлсэн.

Закхайг хүмүүс бусад албан
татвар хураагчийн адил

“нүгэлтэн” гэж тооцдог байв
(7-р иш; Матай 9:10).

Ямартай ч, Закхайд аврал
хэрэгтэй байлаа (9-р иш).

Тэрээр Их Эзэний хувьд
алдагдсан нэгэн байсан учраас тэр.



Үүнээс харахад алдагдаж мөхөхийн
эсрэг нь хайж аврах явдал юм. Олон
хүн авралын эсрэгийг там гэж бодож
явдаг. Гэтэл тийм биш, алдагдсан,
мөхсөн байдал нь хүн аврагдахад
саад болохгүй, харин ч тэр хүнийг
аврагдахад бэлэн болгодог. Их Эзэнд
олдож аврагдахын тулд хүн эхлээд
төөрч алдагдсан байх учиртай.

Хүн
Их Эзэнд
олдож аврагдахын
тулд
эхлээд
төөрч алдагдсан
байх учиртай.



“Хүүд итгээгүй мөхөх” хүн тамд орох уу? 8

Сайн хоньчин 99
хонио хотод нь
үлдээгээд
алдагдсан ганц
хониныхоо араас
явсан. Их Эзэн
маань яг л тэр
хоньчин шиг.



Тэрээр алдсан бүхнээ заавал эрж хайгаад бас
заавал олох болно.

Түүнд хангалттай хүч чадал, мэргэн ухаан
байхгүй гэж үү?

Үхэл Түүнд саад болно гэж үү?

*Дараагийн нийтлэлд галт нуурын утга учрыг авч
үзэх болно.*

Ашигласан эх сурвалж

---Ариун Библи (2004; 2013; 2019). Улаанбаатар: Ариун Бичээс
Нийгэмлэг. Энэ судалгаанд АБ гэж товчилсон. Орчуулга
тодруулаагүй тохиолдолд АБ-с авсан гэсэн үг.

---Библи (2015). Улаанбаатар : Монголын Библийн Нийгэмлэг. Энэ
судалгаанд ББ гэж товчилсон.

---Стандарт Монгол Орчуулгын апп (2023). Энэ судалгаанд СМО гэж
товчилсон.

---Strong, J. (1890). Strong's exhaustive concordance of the Bible (with
Greek and Hebrew Lexicons). www.blueletterbible.org